

© “Мөнгө, санхүү, баялаг” сэтгүүл 2019

ДНБ-ИЙГ ОРЛОГЫН АРГААР ТООЦОХ НЬ

С.Дэмбэрэл¹

Монгол Улсын Үндэсний статистикийн хороо, Монголбанкны Эдийн засгийн судалгаа, сургалтын хүрээлэн, Эдийн засгийн судалгааны эрдэм шинжилгээний хүрээлэнгээс хамтран 2018 оны арванхоёрдугаар сарын 12-ны өдөр зохион байгуулсан “Үндэсний тооцооны систем · 2018” бага хуралд Монголбанкны Эдийн засгийн судалгаа, сургалтын хүрээлэнгийн захирал С.Дэмбэрэлийн тавьсан илтгэлийг Та бүхний анхааралд толилуулж байна.

Үйлдвэрлэлийн аргаар ДНБ-ийг тооцоход ДНБ = үндсэн үнээр байгаа нэмэгдэл өртөг + бүтээгдэхүүний татаасыг хассан татвар (*бүтээгдэхүүний цэвэр татвар*) гэсэн томъёогоор тооцдог. Нэмэгдсэн өртгийг үндсэн үнээр байгаа нийт бүтээгдэхүүн (*output*)-ээс худалдан авагчийн үнээр илэрхийлэгдсэн завсрын хэрэглээг хассан ялгавраар тодорхойлдог ба энэ нь ажиллагчдын хөдөлмөрийн нөхөн олговор болон (*үйлдвэрлэлийн үйл ажиллагааны татаасыг хассан бусад татварын мэдээлэл байгаа нөхцөлд*) үйл ажиллагааны нийт ашиг (*gross operating surplus*)-ийг үлдэгдлийн аргаар тооцдогтой ижил гэсэн хэрэг юм. Зах зээлийн нийт бүтээгдэхүүн буюу гарцыг хэмжих боломжтой үед энэхүү үлдэгдлийн аргыг хэрэглэдэг. Үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ-ий адил орлогын аргаар тооцсон ДНБ нь нэмэгдсэн өртгийг хэмждэг бөгөөд гэхдээ гол хоёр ялгаа байдаг. Үүнд:

1. Орлогын аргаар тооцсон ДНБ нь нэмэгдсэн өртгийг бүрэлдвэр бүрийн нийлбэрээр тооцдог бол үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ нь үлдэгдлийн аргаар буюу нийт үйлдвэрлэл ба завсрын хэрэглээний ялгавраар тооцдог. Орлогын аргаар тооцсон ДНБ нь:

Нэмэгдсэн өртөг = Ажиллагчдын хөдөлмөрийн нөхөн олговор (*compensation of employees*) + холимог орлого + үйлдвэрлэлийн татаасыг хассан бусад татвар + үйл ажиллагааны нийт ашиг (*gross operating surplus*)

Үйл ажиллагааны нийт ашиг = Үйл ажиллагааны цэвэр ашиг + Үндсэн хөрөнгийн хэрэглээ (*consumption of fixed capital*). Нэмэгдсэн өртгийг шууд хэмжинэ гэдэг нь үйл ажиллагааны нийт ашгийг шууд хэмжинэ гэсэн хэрэг бөгөөд эндээс хоёр дахь суурь ялгаа гарч ирдэг:

Орлогын аргаар тооцсон ДНБ-ий статистикийн нэгж нь энтэрпрайс нэгж (*enterprise unit*) байдаг бол үйлдвэрлэлийн аргын хувьд энэ нь истэблишмент

¹ Монголбанкны Эдийн засгийн судалгаа, сургалтын хүрээлэнгийн захирал.

Цахим шуудан: demberel.s@mongolbank.mn

нэгж (*establishment unit*) байдаг. Статистик нэгж нь энтэрпрайс нэгж буй үед элэгдэл хорогдлын шимтгэл, ашиг буюу цэвэр орлого гэх мэт бизнесийн нябо бүртгэлд хэрэглэгддэг томъёоллын тоон утгыг шууд хэмжиж болдог гэсэн хэрэг юм.

Орлогын аргаар тооцсон ДНБ-ий задаргааг Хүснэгт 1-д харууллаа.

Хүснэгт 1

Дотоодын нийт бүтээгдэхүүн
(орлогын аргаар, сая төгрөг, оны үнээр)

	ДНБ (орлогын аргаар)				
	2005	2010	2015	2016	2017
1. ДНБ	3041405.7	9756588.4	23150385.6	23942866.4	27167034.7
2. Ажиллагчдын цалин хөлс	712094.8	2199200.4	6248550.0	6599559.6	7633816.9
3. Үндсэн хөрөнгийн хэрэглээ	228008.0	686091.9	1949984.4	2236531.2	2623043.7
4. Үйлдвэрлэл, импортын татвар, цэвэр	412836.0	1017319.9	1979031.6	2078997.1	2666117.9
5. Үйл ажиллагааны ашиг/ холимог орлого, цэвэр	1696467.0	5853976.2	12972819.6	13027778.5	14244056.2
Бүрэлдвэрүүдийн жилийн дундаж нэрлэсэн өсөлт, %					
1. ДНБ	-	26.3	18.9	3.4	13.5
2. Ажиллагчдын цалин хөлс	-	25.3	23.2	5.6	15.7
3. Үндсэн хөрөнгийн хэрэглээ	-	24.6	23.2	14.7	17.3
4. Үйлдвэрлэл, импортын татвар, цэвэр	-	19.8	14.2	5.1	28.2
5. Үйл ажиллагааны ашиг/ холимог орлого, цэвэр	-	28.1	17.3	0.4	9.3
6. 5:1, %	55.8	60.0	56.0	54.4	52.4
7. 4:5, %	24.3	17.4	15.3	16.0	18.7
8. 5:2, дахин	2.38	2.66	2.08	1.97	1.86

Шигтгээ 1

Бизнесийн нябо бүртгэлээр үйл ажиллагааны нийт ашгийг нь шууд тооцох боломжтой бизнесийн байгууллагуудад орлогын аргыг хэрэглэдэг бөгөөд гэхдээ компанийн нябо бүртгэл, үндэсний тооцооны ашиг, орлогын ойлголт ялгаатай байдаг гэдгийг харгалзах нь чухал билээ.

Аливаа үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, хөдөлмөр, хөрөнгө болон завсрын хэрэглээ гэсэн “үйлдвэрлэлийн гурван хүчин зүйл”-ээс бүрэлддэг тул үйлдвэрлэлийн, эцсийн ашиглалтын аргаар тооцсон болон орлогын аргаар тооцсон ДНБ-ий хувьд дараах тэнцэтгэл мөрдөгдөнө гэсэн үг юм.

Нийт гарц (бүх нэмэгдсэн өртгийн нийлбэр) = орлого (ажиллагчдын хөдөлмөрийн хөлс + компаниудын ашиг орлого) = эцсийн эрэлт (хэрэглээ + хөрөнгийн нийт бүрдэлт + цэвэр экспорт)

Хүснэгт 1-ээс харахад:

1. Орлогын бүрэлдвэрүүдийн нэрлэсэн өсөлт сүүлийн долоон жилд буурч ирсэн хандлагатай, ялангуяа 2016 онд үйл ажиллагааны ашиг/холимог орлого, цэвэр (*үндсэн хөрөнгийн хэрэглээг хассан*) утгаараа 1 хувь ч хүрэхгүй өсөлттэй байсан ба 2017 онд харьцангуй сэргэлт ажиглагдаж байна.

2. Ажиллагчдын цалин хөлс буюу хөдөлмөрийн хүчин зүйлийн нэрлэсэн өсөлт хөрөнгийнхөөс илүү хурдацтай өсч байсан хандлагатай байна.

3. Үндсэн хөрөнгийн хэрэглээний өсөлт ДНБ-ийхээс илүү өсөлттэй байгаа нь нэг талаас техникийн дэвшлийн үр дүнд үндсэн капитал шинэчлэгдэж буйг харуулахын зэрэгцээ түүний насжилтыг мөн харуулж байна.

4. Нийт эдийн засгийн хэмжээнд ашигт ажиллагааны ерөнхий түвшин ямар буйг (5:1) харьцаа харуулах бөгөөд 2017 оны байдлаар 2005 оны түвшингээс доогуур орсон байна. Гэхдээ ашигт ажиллагааны түвшин буюу маржин (margin) харьцааг зөвхөн бизнесийн сектор дээр тооцдог гэдгийг харгалзах хэрэгтэй.

5. (4:5) буюу үйлдвэрлэл, импортын татвар ба үйл ажиллагааны ашиг/холимог орлогын харьцаа харьцангуй буурч ирсэн хандлагатай байна.

6. Хөрөнгө ба хөдөлмөрийн харьцааны үзүүлэлтийн хандлага сүүлийн 12 жилд ерөнхийдөө буурч ирсэн бөгөөд энэ нь хэдийгээр ажрахуйн нэгжүүдийн ашиг орлого хөдөлмөрийн нөхөн олговортой харьцуулахад 1,9-2,4 дахин их байгаа ч хөдөлмөрийн зардлын хэмжээ илүү хурдацтай өсч ирснээр тайлбарлагдаж байна.

Орлогын аргаар тооцсон ДНБ-ий задаргааг үйлдвэрлэлийн салбараар мөн гаргадаг бөгөөд үүнийг нөөц, ашиглалтын хүснэгт, салбар хоорондын тэнцлээс гаргаж болно. Энэ аргаар тооцсон ДНБ-ий бүрэлдэхүүний зарим гол харьцаа үзүүлэлтийг Хүснэгт 2-т тооцсон болно.

Хүснэгт 2

Орлогын аргаар тооцсон ДНБ-ий бүрэлдвэрүүдийн харьцаа үзүүлэлтүүд
(гол салбар, салбар хоорондын тэнцлээр)

	2000					2005					2010					2015					2016				
	A	B	C	D	E	A	B	C	D	E	A	B	C	D	E	A	B	C	D	E	A	B	C	D	E
1. Хөлөө аж ахуй	15.0	92.6	38.7	25.0	2.7	18.9	94.8	20.7	14.9	-8.8	24.1	95.4	33.9	18.5	-5.8	10.9	91.3	29.0	6.3	7.6	34.1	96.3	33.2	14.6	-0.1
2. Уул уурхай, олборлолт	3.7	62.7	62.6	96.4	116.8	8.5	82.4	34.0	28.1	103.6	6.6	81.2	46.0	39.8	94.6	3.6	67.2	48.4	31.5	151.5	4.5	72.6	42.0	24.3	136.3
3. Боловсруулах үйлдвэрлэл	6.3	81.3	49.7	33.3	66.5	2.7	66.3	70.6	75.4	29.8	4.0	75.7	68.2	48.1	0.02	2.9	63.9	63.7	29.7	1.5	3.2	67.9	63.1	33.9	6.3
4. Эрчим хүч	2.8	52.9	49.5	19.1	-	0.8	42.8	58.1	38.3	-38.3	2.2	21.2	73.7	37.8	-37.1	0.1	7.0	62.3	56.0	-55.6	0.2	12.8	64.9	23.0	-22.8
5. Барилга	0.55	31.9	76.6	129.5	-129.5	1.5	53.0	68.8	109.4	-108.3	1.2	48.4	76.4	165.3	-158.1	1.6	57.0	70.9	92.7	-82.9	1.0	43.8	72.5	92.0	-86.1
6. Тээвэр, холбоо	2.0	51.9	59.6	71.5	-71.5	2.4	69.2	54.2	66.6	2.7	3.0	69.6	48.8	53.1	-23.2	1.9	56.7	49.4	44.5	-4.0	1.6	51.8	49.7	50.0	-15.5
7. Санхүү, даатгал	8.8	82.9	32.8	12.1	-12.1	3.5	76.7	47.0	13.3	-7.8	1.3	51.5	34.4	16.0	-8.0	2.7	68.5	21.2	7.7	-5.5	2.2	64.3	24.2	7.9	-4.5
8. Ул хөдлөх хөрөнгө	7.2	84.7	18.8	4.1	-4.1	3.5	76.6	45.7	24.6	-24.3	48.3	97.1	23.5	5.3	-5.2	32.4	95.3	19.6	4.3	-4.3	28.2	94.1	18.6	2.0	-1.9
9. Худалдаа	8.3	81.3	32.4	14.2	-14.2	4.0	74.6	38.7	15.3	11.6	3.3	70.5	38.8	18.3	28.2	2.6	68.3	34.0	9.6	9.6	1.6	56.9	37.1	14.0	18.8
Нийт эдийн засаг	6.6	82.4	38.7	44.4	-16.1	3.2	73.5	48.9	65.3	0.2	2.7	66.8	49.0	60.7	-8.7	2.1	61.0	45.8	46.4	3.3	2.0	59.3	45.7	46.5	8.3

Тайлбар: А - үйл ажиллагааны ашиг/холимог орлого + бусад орлого ба ажилчдын цалингийн харьцаа

В - үйл ажиллагааны ашиг/холимог орлого ба үндсэн үнээр буй нэмэгдэл өртгийн харьцаа,

С - нийт үйлдвэрлэлд заверын хэрэглэний эзлэх хувь,

Д - импорт ба нэмэгдэл өртгийн харьцаа

Е - тухайн салбарын экспорт, импортын зөрүүг нэмэгдэл өртөг (үндсэн үнээр)-т харьцуулсан хувь, %

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, зохиогчийн тооцоо

Хүснэгт 2-оос доорх дүгнэлтийг хийж болно. Үүнд:

1. А харьцаа бол үндсэндээ хөрөнгө ба хөдөлмөрийн харьцааг харуулах бөгөөд нийт эдийн засгийн хувьд уг харьцаа буурч ирсэн, гол салбаруудын хувьд хөрөнгө болон хөдөлмөрийн багтаамжаас хамааран өөр өөр харьцаатай, эдийн засгийн орчилын өөрчлөлтөнд илүү мэдрэмтгий байгаа хандлагатай байна.

2. В харьцаа бол татварын өмнөх ашиг ба үндсэн үнээр буй нэмэгдэл өртгийн харьцааг харуулж буй тул үндсэндээ нийт эдийн засгийн болон салбаруудын ашигт ажиллагааны ерөнхий түвшинг харуулж байна. Хамгийн бага түвшинтэй нь барилгын салбар, хамгийн өндөр түвшинтэй нь хөдөө аж ахуй, уул уурхай, үлд хөдлөх хөрөнгийн салбар байна. Ерөнхийдөө ашигт ажиллагааны түвшин буурч ирсэн хандлагатай байна.

3. Нийт үйлдвэрлэлд завсрын хэрэглээний эзлэх хувийн жин 2000-2010 онд нэмэгдэх хандлагатай байсан ба 2010 оноос хойш ерөнхийдөө тогтворжсон байна (*С харьцаа*). Энэ харьцаатай төстэй импорт ба нэмэгдсэн өртгийн харьцаа буюу “импортын багтаамж” гэж нэрлэж болох үзүүлэлтийн хувьд мөн ижил хандлагатай байгаа бөгөөд 2010 он хүртэл нэмэгдэж ирсэн ба түүнээс хойш буурсан хандлагатай байна.

4. Е харьцаа буюу гадаад худалдааны нэрлэсэн тэнцэл ба үндсэн үнээр буй нэмэгдэл өртгийн харьцаа сонирхолтой дүр зураг харуулж байна.

- а) Нийт эдийн засгийн хувьд энэ харьцаа 2000-2010 онд үндсэндээ сөрөг утгатай, гэхдээ буурч ирсэн хандлагатай байгаа бол сүүлийн жилүүдэд эерэг утгатай болж, 2016 оны байдлаар 8,3 хувь болсон байна.
- б) Салбараар авч үзвэл холимог дүр зураг харагдаж байгаа бөгөөд уул уурхайн салбарын тэнцэл нь уг салбарт бий болсон нэмэгдсэн өртгөөс их тул харьцаа нь байнга 1-ээс их утгатай буюу худалдааны тэнцлийг эерэг болгоход хамгийн их хувь нэмэр оруулж иржээ. Үүний дараа худалдаа, боловсруулах үйлдвэр эерэг утгатай байгаа ч энэ нь байнга буурч ирсэн байна.

Бусад салбарын хувьд уг харьцаа байнга сөрөг утгатай, түүний дотор барилга, эрчим хүчний салбарынх хамгийн их сөрөг утгатай буюу худалдааны тэнцэлд сөрөг “хувь нэмэр” оруулж ирсэн байна. Өөрөөр хэлбэл, эдгээр салбарт импорт орлох бодлого хэрэгжүүлэх, импортыг зохистой болгох орон зай байсаар байна гэсэн хэрэг юм.

Хүснэгт 3

Ашиглалт (нийт эрэлт)-ын хүснэгт (худалдан авагчийн үнээр, %)

№	Ашиглалт	2005							2010							2015							2016						
		1	2	3	4	5	6	7	1	2	3	4	5	6	7	1	2	3	4	5	6	7	1	2	3	4	5	6	7
1.	ХАА, ан агнуур, ойн аж ахуйн бүтээгдэхүүн	18,7	-	16,5	49,3	2,5	13,0	11,8	9,1	-	0,1	39,8	3,8	6,3	8,3	8,3	-	19,1	32,6	4,8	8,9	9,5	8,1	-	18,1	45,9	4,3	8,7	9,0
2.	Хүдэр, эрдэс болис	1,0	-	0,2	23,2	52,9	20,8	14,2	0,3	-	-	22,4	69,1	19,6	12,8	0,3	-	-	8,0	66,8	21,5	13,9	0,3	-	-	15,5	58,2	20,8	13,5
3.	Боловсруулах үйлдвэрийн бүтээгдэхүүн	37,5	0,7	43,6	27,5	17,4	28,2	33,9	49,1	-	42,3	82,6	12,7	34,4	38,7	52,0	-	20,9	59,6	16,2	31,4	35,3	49,5	-	27,4	38,6	23,2	32,0	34,2
4.	Барилга, барилгын ажил, үйлчилгээ	-	0,8	34,3	-	0,1	5,9	4,7	-	-	39,6	-	0,1	8,7	7,7	-	-	56,7	-	0,6	8,2	7,7	-	-	51,6	-	0,5	7,5	7,8
5.	Санхүүгийн зуучлалын үйлчилгээ	1,7	-	-	-	0,5	0,7	3,2	1,5	-	-	0,4	0,7	1,8	2,4	-	-	-	-	0,3	1,1	3,4	3,4	-	-	-	0,5	1,4	3,9
6.	Тээвэр, шуудангийн үйлчилгээ	16,5	0,1	-	-	16,0	11,4	10,2	10,5	0,3	-	4,9	5,3	6,5	4,8	-	-	-	-	4,5	3,4	5,2	4,7	-	-	-	4,4	3,3	5,3
7.	Үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн бусад үйлчилгээ	14,7	2,1	5,5	-	0,1	6,1	5,9	14,4	-	-	0,1	5,1	4,4	12,3	-	-	-	-	0,1	5,0	4,4	13,1	-	0,7	-	0,1	5,1	4,1
8.	Боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээ	3,0	48,5	-	-	-	4,4	3,7	5,4	46,8	-	-	5,7	3,8	7,2	42,2	-	-	-	0,2	6,9	4,5	7,5	41,4	-	-	0,2	7,1	4,6
	Бүгд	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100

Тайлбар:

- 1 – өрхийн болон ӨҮАББ-ын хэрэглээ
- 2 – төрийн удирдлагын хэрэглээ
- 3 – үндсэн хөрөнгийн нийт хуримтлал
- 4 – эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт, үнэт зүйлсийн хуримтлал
- 5 – экспорт
- 6 – энсийн хэрэглээ
- 7 – нийт хэрэглээ, худалдан авагчийн үнээр

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, зохиогчийн тооцоо

Хүснэгт 3-аас харахад:

1. Өрхийн эцсийн хэрэглээний зардлын бүтээгдэхүүний ангилал буюу өрхүүд аль салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээнд хэрэглээгээ зарцуулсан байдлыг 2005-2016 оны байдлаар харахад эцсийн хэрэглээний зардлын 50 орчим хувь нь боловсруулах үйлдвэрийн бүтээгдэхүүн, үйлчилгээнд 12-15 хувь нь үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн бусад үйлчилгээнд, 9 орчим хувь нь хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнд, 5 хувь нь тээвэр, шуудангийн үйлчилгээнд (*хувь хэмжээ нь буурч ирсэн*), 8 хувь нь (*өсч ирсэн*) боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээнд ногдож байна.

2. Төрийн удирдлагын хэрэглээ үндсэндээ:

- а) Төрийн удирдлага, нийгэмд үзүүлэх бусад үйлчилгээ
- б) Боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээ гэсэн 2 хэсэгт зарцуулагдаж байгаа бөгөөд б хэсгийн үйлчилгээ 49-41 хувь болж буурсан, харин өрхүүдийн энэ зардлын эзлэх хувь хэмжээ нэмэгдэж ирсэн хандлагатай байна. Боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээнд зарцуулж буй төрийн зардал, өрхүүдийн энэ зориулалтаар зарцуулж буй зардал хоёрын нийлбэрийг өрхийн бодит хэрэглээ гэж нэрлэдэг ба 2016 онд 48,9 хувь байжээ.

3. Үндсэн хөрөнгийн хуримтлалын хувьд барилга, барилгын ажил үйлчилгээ, боловсруулах үйлдвэрийн бүтээгдэхүүнд голчлон оногдож байна.

4. Эргэлтийн хөрөнгийн өөрчлөлтийн хувьд 1-3 дугаар бүтээгдэхүүний ангилалд хамрагдаж байгаа нь эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ-ий өсөлтийн хувь нэмрийн тооцоонд анхаарвал зохих баримт гэдгийг харуулж байна.

5. Гадаад эрэлт буюу экспортын хувьд хүдэр, эрдэс бодис, боловсруулах үйлдвэрийн бүтээгдэхүүн зонхилж, боловсруулах үйлдвэрийн бүрэлдэхүүний эзлэх хувь нэмэгдэж ирсэн хандлагатай байна. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, тээвэр, шуудангийн үйлчилгээ 3-6 хувь орчимд тогтвортой хадгалагдаж байна.

Эцсийн хэрэглээ, нийт хэрэглээний талаас нь үзвэл боловсруулах үйлдвэрийн бүтээгдэхүүн зонхилж, түүний дараа хүдэр, эрдэс бодис, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн орж байгаа ч сүүлийн жилүүдэд хүдэр, эрдэс бодисын хувийн жин илүү нэмэгдсэн нь нийт эдийн засгийн бүтцийн өөрчлөлтөд уул уурхайн бүтээгдэхүүн илүү их нөлөөлөх хандлагатай, өөрөөр хэлбэл, эдийн засгийн үндсэн түүхий эдийн бүтэц улам бүр лавширч буйг, эдийн засгийн гадаад цочролоос хамаарах байдал нэмэгдэж буйг харуулж байна.

Нөөц болон ашиглалтын хүснэгтийн зарим гол харьцааны өөрчлөлт
(оны үнээр, хувиар)

	2016							2010						
	A	B	C	D	E	F	G	A	B	C	D	E	F	G
1. ХАА-н бүтээгдэхүүн	9,9	1,5	34,5	8,1	18,1	45,9	4,3	9,3	1,4	34,4	9,1	0,1	39,8	4,0
2. Хүдэр, эрдэс бодис	16,3	0,1	44,7	0,3	0,0	15,5	58,2	14,4	0,1	49,0	0,3	0,0	-22,4	72,7
3. Боловсруулах үйлдвэрийн бүтээгдэхүүн	15,6	65,2	16,3	49,5	27,7	38,6	23,2	14,7	86,1	70,9	49,0	42,3	82,6	13,3
4. Барилга, барилгын ажил, үйлчилгээ	9,5	2,1	76,5	0,03	51,6	0,0	0,5	10,4	0,2	81,0	0,01	39,6	0,0	0,1
5. Худалдаа үйлчилгээ	10,2	0,0	39,3	0,0	0,0	0,0	0,0	11,1	0,0	40,2	0,0	0,0	0,0	0,0
6. Тээвэр, шуудангийн үйлчилгээ	6,4	4,5	54,2	4,7	0,0	0,0	4,4	8,2	3,7	52,2	10,5	0,0	0,0	5,2

Тайлбар: F – Тухайн (салбар) бүтээгдэхүүний экспортын нийт экспортын эзлэх хэмжээ;
G – Тухайн (салбар) эргэлтийн хөрөнгийн өөрчлөлтийн эргэлтийн хөрөнгийн нийт өөрчлөлтөнд эзлэх хэмжээ;
E – Тухайн (салбар) бүтээгдэхүүний үндсэн хөрөнгийн нийт хуримтлалын нийт ҮХ хуримтлалд эзлэх хувийн жин;
A – Үндсэн үнээр буй дотоодын үйлдвэрлэгчид тухайн бүтээгдэхүүний эзлэх хувийн жин;
B – Нийт импортод тухайн бүтээгдэхүүний эзлэх хувийн жин;
C – Үндсэн үнээр буй нийт үйлдвэрлэлд тухайн салбарын бүтээгдэхүүнийг бүх салбарт ашигласан хэмжээний эзлэх хувийн жин (*завсрын бүтээгдэхүүн, нийт үйлдвэрлэл, %*);
D – Тухайн (салбар) бүтээгдэхүүний өрхийн болон ӨҮАББ-ын хэрэглээний нийт өрхийн болон ӨҮАББ-ын хэрэглээнд эзлэх хувийн жин.

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, зохиогчийн тооцоо

Хүснэгт 5

Эцсийн ашиглалт болон түүний бүрэлдвэрүүдийн бүтээгдэхүүний ангиллын хуваарилалт (хувиар)

Бүтээгдэхүүн	Ашиглалт							Дефляторууд						
	A	B	C	D	E*	F**	G	A	B	C	D	E	F	G
2005														
ХАА, ан агнуур, ойн аж ахуйн бүтээгдэхүүн	49,3	0,0	21,6	22,3	6,8	13,0	10,3							
Хүдэр, эрдэс бодис	1,7	0,0	0,2	6,6	91,6	20,8	0,4							
Боловруулах үйлдвэрийн бүтээгдэхүүн	45,6	0,2	26,4	5,7	22,1	28,2	65,7							
Барилга, барилгын ажил, үйлчилгээ	0,0	1,0	98,7	0,0	0,3	5,9	1,2							
Тээвэр, шуудангийн үйлчилгээ	49,5	0,1	0,0	0,0	50,4	11,4	27,5							
Үл хөдлөх хөрөнгийн үйлчилгээ	82,1	2,3	15,3	0,0	0,3	6,1	0,6							
Боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээ	23,5	76,5	0,0	0,0	0,1	4,4	12,9							
Нийт эдийн засаг	34,2	6,9	17,1	5,9	35,9	100,0	26,0							
2010														
ХАА, ан агнуур, ойн аж ахуйн бүтээгдэхүүн	51,1	0,0	0,2	30,6	18,0	6,3	4,2							
Хүдэр, эрдэс бодис	0,5	0,0	0,0	-5,5	105,0	19,6	0,2							
Боловруулах үйлдвэрийн бүтээгдэхүүн	50,3	0,0	27,1	11,7	11,0	34,4	63,5							
Барилга, барилгын ажил, үйлчилгээ	0,03	0,0	99,7	0,0	0,3	8,7	0,5							
Тээвэр, шуудангийн үйлчилгээ	70,1	2,2	0,0	0,0	27,7	5,3	11,7							
Үл хөдлөх хөрөнгийн үйлчилгээ	99,3	0,0	0,0	0,0	0,7	5,1	2,4							
Боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээ	33,2	66,1	0,0	0,0	0,7	0,6	7,4							
Нийт эдийн засаг	35,2	8,1	22,0	4,9	29,8	100,0	23,6							

2015

ХАА, ан агнуур, ойн аж ахуйн бүтээгдэхүүн	37,7	0,0	30,3	15,1	16,9	8,9	1,9
Хүдэр, эрлэс бодис	0,5	0,0	0,0	1,5	98,0	21,5	0,2
Боловруулах үйлдвэрийн бүтээгдэхүүн	67,5	0,0	9,4	7,9	15,2	31,4	55,8
Барилга, барилгын ажил, үйлчилгээ	0,1	0,0	97,5	0,0	2,4	8,2	4,8
Тээвэр, шуудангийн үйлчилгээ	57,7	0,3	0,0	0,0	42,1	3,4	7,3
Үл хөдлөх хөрөнгийн үйлчилгээ	99,4	0,0	0,0	0,0	0,6	5,0	1,9
Боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээ	42,3	56,9	0,0	0,0	0,8	6,9	10,5
Нийт эдийн засаг	40,8	9,4	14,1	4,2	31,6	100,0	20,1

2016

ХАА, ан агнуур, ойн аж ахуйн бүтээгдэхүүн	34,8	0,0	29,3	18,8	17,0	8,7	3,7
Хүдэр, эрлэс бодис	0,5	0,0	0,0	2,7	96,8	20,8	0,1
Боловруулах үйлдвэрийн бүтээгдэхүүн	58,4	0,0	12,2	4,3	25,0	32,0	51,6
Барилга, барилгын ажил, үйлчилгээ	0,1	0,0	97,5	0,0	2,3	7,5	5,3
Тээвэр, шуудангийн үйлчилгээ	54,1	0,3	0,0	0,0	45,6	3,3	15,4
Үл хөдлөх хөрөнгийн үйлчилгээ	97,0	0,0	2,1	0,0	0,9	5,1	5,7
Боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээ	40,0	59,1	0,0	0,0	0,9	7,1	10,3
Нийт эдийн засаг	37,7	10,1	14,1	3,6	34,5	100,0	20,4

Тайлбар:

- A – Өрхийн болон ӨУАББ-ын хэрэглээний эцсийн хэрэглээнд эзлэх хэмжээ, %
- B – Төрийн удирдлагын хэрэглээний эцсийн хэрэглээнд эзлэх хэмжээ, %
- C – Үндсэн хөрөнгийн нийт хуримтлалын эцсийн хэрэглээнд эзлэх хэмжээ, %
- D – Эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт, үнэт зүйлсийн хуримтлалын эцсийн хэрэглээнд эзлэх хэмжээ, %
- E – Эцсийн хэрэглээнд эзлэх экспортын хэмжээ, %
- F – Тухайн бүтээгдэхүүн (салбар)-ийн импортын үндсэн үнээр буй нийт нөөцөд эзлэх хэмжээ, %
- A-F нь үндсэн үнээр буй эцсийн ашиглалт болон түүний бүрэлдвэрүүд болно. Эдийн засгийн өсөлтөнд оруулсан хувь нэмрийг тооцоход шаардлагагүй цэвэр экспортын импортын бүрдэл ороогүй болно.
- Тиймээс дефляторуудын G хэсэгт импортын үнийн дефляторыг тавьсан болно (суурь он = 2010). Үндсэн үнээр буй эцсийн ашиглалт болон түүний бүрэлдвэрүүдийн дефляторыг нийт эдийн засаг гэсэн хэсэгт харууллаа.
- Хүснэгт 5-ын мөрүүдэд эцсийн ашиглалтад тухайн бүрэлдвэр бүрийн эзлэх хувийн жишиг, баганы хэсэгт бүрэлдвэр бүсийн тухайн (салбар) бүрэлдэхүүний хэрэглээг харуулж буй болно.
- G – нөөц ашиглалтын хүснэгтийн импорт буюу гадаад нийлүүлэлтийн үндсэн үнээр буй нийт нөөцөнд эзлэх буй хувь хэмжээг харууллаа. Нийт эдийн засгийн хэсэгт бүрэлдвэр бүрийн эцсийн ашиглалтад эзлэх буй хувь хэмжээ болно.

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, зохиогчийн тооцоо